

КРЕДИТ КАРТЫН ГЭРЭЭ

..... оны сарын өдөр

Дугаар №.....

Улаанбаатар хот

Энэхүү **КРЕДИТ КАРТЫН ГЭРЭЭ** /цаашид “Гэрээ” гэнэ/-г Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Улаанбаатар хотын банк, Монголбанкны холбогдох журам, дүрмийг үндэслэн,
Нэг талаас Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 15160, Д.Сүхбаатарын талбай 11 хаягт байрлах "УЛААНБААТАР ХОТЫН БАНК" /цаашид “Банк” гэх/,
Нөгөө талаас _____ тоот хаягт байрлах _____ тоот регистрийн дугаартай _____ овогтой _____ (цаашид Карт эзэмшигч буюу “КЭ” гэх) (хамтад нь “Талууд” гэх) нарын хооронд харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээ нь Банк Кредит КЭ-д түүний хэрэглээнд зориулан тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаа, хүү, шимтгэл хураамж, эргэн төлөгдөх нөхцөлгэйгөөр зээлжих эрх нээх, Кредит КЭ нь уг нөхцөлийн дагуу Ашигласан зээлтэй холбогдуулан шимтгэл, хураамж, Ашигласан зээлийн хүү, зарцуулсан зээлийн дүн зэрэг нийт төлбөрийг эргэн төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Энэ гэрээнд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1 “Төлбөрийн карт” (цаашид “карт” гэх) гэж “төлбөрийн карт” гэж олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкны шаардлагыг нэгэн зэрэг, эсхүл аль нэгийг нь хангасан карт эзэмшигч (цаашид “КЭ” гэх)-д төлбөр хийх боломж олгодог төлбөрийн хэрэгслийг;
 - 1.2.2 “Картын ПИН код” гэж төлбөрийн КЭ-ийг картын жинхэнэ эзэмшигч гэдгийг нотлох 4-6 оронтой нууц кодыг;
 - 1.2.3 “CVV код” гэж картын бэлдэцийн ар хэсэгт хэвлэгдсэн, интернэт худалдан авалт хийхэд ашигладаг 3 оронтой тоог;
 - 1.2.4 “Интернет ПИН код” гэж КЭ өөрийн картаа ашиглан интернет худалдан авалт хийхэд тухайн КЭ гэдгийг нотлох 4 оронтой нууц дугаарыг;
 - 1.2.5 “Үйлчилгээний байгууллага” (цаашид “ҮБ” гэх) гэж бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг төлбөрийн картаар хүлээн авч үйлчлэх талаар Виза интернэшнл болон бусад төлбөрийн картаар үйлчлэгч байгууллагын гишүүн аль нэгэн банк, санхүүгийн байгууллагатай гэрээ байгуулан төлбөр хүлээн авч байгаа байгууллага, хувь хүнийг;
 - 1.2.6 “Хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл” (цаашид “ХШЕН” гэх) гэж Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөрдөгдөх хүү, шимтгэл, хураамжийн хувь хэмжээг тогтоосон, банкны www.ubcbank.mn цахим хуудсанд нийтэлсэн үйлчлүүлэгчиддээ мэдэгдсэн баримт бичигийг;
 - 1.2.7 “Картын жилийн хураамж” гэж ХШЕН-д заасан карт ашигласны төлбөрт жил бүр төлөх төлбөрийг;
 - 1.2.8 “Бэлэн мөнгөний шимтгэл” гэж Банк болон бусад гадаад, дотоодын арилжааны банк, санхүүгийн байгууллагын салбар болон АТМ-ээс бэлэн мөнгө авсан дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.9 “Шилжүүлгийн гүйлгээний шимтгэл” гэж Картын данснаас бэлэн бусаар шилжүүлсэн гүйлгээний дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.10 “Картын өдрийн зарцуулалтын лимит” гэж ХШЕН-д тогтоосон Картаар хийгдэх гүйлгээний өдрийн зарцуулалтын дүн, тооны хязгаарыг;
 - 1.2.11 “Картын нэмэлт үйлчилгээний шимтгэл” гэж Карт дахин захиалах, дэд карт захиалах, Картын ПИН код солих, картын Интернет ПИН кодыг идэвхжүүлэх, картын үлдэгдэл шалгах болон бусад үйлчилгээнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.12 “Кредит карт” гэж Банкны баталсан зээлийн эрхийн хүрээнд зарцуулалт хийн, ХШЕН-д заасан хугацаанд хүү, шимтгэлтэйгээр эргэн төлөх нөхцөлтэй дотоодод болон олон улсад ашиглагдах боломжтой Улаанбаатар хотын банкны төлбөрийн картыг;
 - 1.2.13 “Кредит картын зээлийн лимит” гэж харилцагчийн хүсэлтийг үндэслэн Банкнаас тогтоосон Кредит картын зээлийн ашиглах боломжит дээд хэмжээг;
 - 1.2.14 “Кредит зээлийн хугацаа” (цаашид “Зээлийн хугацаа” гэх) гэж Банкнаас тогтоосон кредит зээлийн лимитийн хугацааг;
 - 1.2.15 “Ашигласан зээл” гэж Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээ хэлбэрээр зарцуулсан Кредит картын зээлийн хэмжээг;
 - 1.2.16 “Бэлэн зарлага” гэж Банк болон бусад банкаар дамжуулан картын дансаар хийгдэх дараах зарлагын, шилжүүлгийн болон төлбөрийн гүйлгээг ойлгоно. Үүнд:
 - АТМ-р хийгдэх зарлагын гүйлгээ;
 - Банкны салбар нэгжүүдэд хийгдэх зарлагын гүйлгээ;
 - АТМ, Салбар нэгж, Цахим банк үйлчилгээгээр хийгдэх шилжүүлгийн гүйлгээ;
 - АТМ, Салбар нэгж, Цахим банк үйлчилгээгээр хийгдэх төлбөрийн гүйлгээ.
 - 1.2.17 “Бэлэн бус гүйлгээ” гэж Кредит карт болон Кредит картын дугаар ашиглан бэлэн бус төлбөр тооцоогоор бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах гүйлгээ;

- 1.2.18 “Төлбөрийн мэдээлэл” гэж тухайн Төлбөрийн циклд Банкны хүлээн авсан, КЭ-ийн картаар хийгдсэн гүйлгээ, төлөх ёстой хураамж, хүү, шимтгэл, төлбөр, Заавал төлөх төлбөр, түүнийг төлөх хугацааны талаар багтаасан мэдээллийн жагсаалт бүхий Карт эзэмшигчид цахим байдлаар эсвэл цаасаар хэвлэн өгсөн баримтыг;
- 1.2.19 “Төлбөрийн цикл” гэж тухайн сарын Төлбөрийн мэдээлэл гаргах өдрөөс дараа сарын Төлбөрийн мэдээлэл гаргах өдөр хүртэл хугацааг;
- 1.2.20 “Төлбөрийн мэдээлэл гаргах өдөр” гэж тухайн Төлбөрийн циклд хамаарах бүхий л гүйлгээтэй холбоотой мэдээллийг багцлан бэлдэж, хэвлэн гаргахад бэлэн болгох ажлын өдрийг;
- 1.2.21 “Төлбөр” гэж тухайн Төлбөрийн циклд картаар хийгдсэн худалдан авалт, бэлэн мөнгө, шилжүүлгийн гүйлгээ, зээлийн лимитийн хэтэрсэн дүн болон Банкинд төлөх хураамж, хүү, шимтгэл зэргийн нийлбэр мөнгөн дүнг;
- 1.2.22 “Заавал төлөх төлбөр” гэж Төлбөр төлөх хугацаанд багтаан заавал төлөх ёстой, тухайн Төлбөрийн циклд Кредит картаар зарцуулсан нийт дүнгийн ХШЕН-д заасан хувь, тухайн Төлбөрийн циклд хамаарах нийт хураамж, хүү, шимтгэл, зээлийн лимитийн хэтэрсэн дүн болон өмнөх Төлбөрийн циклд төлөгдөөгүй Заавал төлөх төлбөр зэргийн нийлбэр мөнгөн дүнг;
- 1.2.23 “Төлбөр төлөх хугацаа” гэж Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийг төлөх өдөр хүртэлх хугацааг;
- 1.2.24 “Төлбөр төлөх өдөр” гэж Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийг төлөх өдрийг;
- 1.2.25 “Хугацаа хожимдуулсны шимтгэл” гэж Төлбөрийн мэдээлэлд заасан заавал төлөх Төлбөрийг Төлбөрийн мэдээлэлд заасан хугацаанд төлөөгүй эсхүл дутуу төлсөн сар тутамд Ашигласан зээлийн хэмжээнээс үл хамааран Банкинд төлөх төгрөгөөр илэрхийлэгдэх мөнгөн дүнг;
- 1.2.26 “Цахим банк үйлчилгээ” (цаашид “Цахим банк” гэх) гэж харилцагч мобайл, интернэт сувгаар дамжуулан авч буй банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх үйлчилгээг.
- 1.2.27 “Карт ашиглагдах хэлбэр” гэж Contactless буюу зайнаас картыг уншуулж ашиглах, EMV chip технологи буюу ЧИП-ээр картыг уншуулж ашиглах, Magnetic Stripe буюу соронзон туузаар картыг уншуулж ашиглах, Карт дээрх мэдээллээ ашиглан интернэт үйлчилгээний байгууллагаар картыг уншуулж ашиглахыг ойлгоно.
- 1.2.28 “ПОС төхөөрөмж” (цаашид “ПОС” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар ҮБ-д байршуулсан, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.29 “МПОС төхөөрөмж” гэж ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.30 “ПОБ төхөөрөмж” гэж карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.31 “Автомат теллер машин” (цаашид “АТМ” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.3 Кредит КЭ нь дараах зөвшөөрлийг Банкинд энэхүү гэрээгээр олгосон бөгөөд Банк дахин аливаа хэлбэрээр Кредит КЭ-ээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагагүй болно. Үүнд:
- 1.3.1 Картын системийн доголдол, техникийн саатлаас үүдэн Кредит картад давхар эсвэл илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн алдаатай гүйлгээг залруулах зорилгоор давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг Кредит картаас үл маргах журмаар суутган авах, эсвэл дансанд битүүмж хийхийг КЭ үүгээр Банкинд зөвшөөрсөн болно.
- 1.3.2 Кредит картын Заавал төлөх төлбөрийг Төлбөр төлөх хугацаанд багтаан бүрэн төлөөгүй хугацаа хожимдуулсан тохиолдолд хугацаа хожимдуулсан дүнг энэхүү гэрээний 5.1.8-д заасан данснаас, тухайн дансан дахь үлдэгдэл нь Төлбөрийг төлж хүрэлцэхгүй бол Кредит КЭ-ийн бусад дансаас банк үл маргах журмаар суутган төлүүлнэ;

ХОЁР. КРЕДИТ КАРТЫН НӨХЦӨЛ

- 2.1. **Кредит зээлийн лимит:**(.....) төгрөг
тоогоор үсгээр
- 2.2. **Кредит картын зориулалт:** Сар тутмын санхүүгийн хэрэгцээ
- 2.3. **Зээлийн хугацаа:** (.....) сар
- 2.4. **Бэлэн зарлагын хүү:** Жилийн (.....) хувь байна. Банк хүүг тооцохдоо Бэлэн зарлага хийсэн дүнг жилийн хүүгээр үржүүлж, 365 хоногт харьцуулах ба бэлэн зарлагын гүйлгээ хийсэн өдрөөс эхлэн эргэн төлөх өдөр хүртэлх хугацаанд тооцно.
- 2.5. **Бэлэн бус гүйлгээний хүү:** Жилийн (.....) хувь байна. Банк хүүг тооцохдоо Бэлэн бус гүйлгээний дүнг жилийн хүүгээр үржүүлж, 365 хоногт харьцуулах ба гэрээнд заасан Төлбөр төлөх өдрөөс эхлэн тооцогдох ба тухайн Төлбөрийг бүрэн төлсөн өдөр хүртэл тооцогдоно.
- 2.6. **Заавал төлөх төлбөр:** тухайн сарын нийт зарцуулсан Төлбөрөөс Төлбөр төлөх хугацааны өмнө заавал төлсөн байхаар ХШЕН-д заасан дүн.
- 2.7. **Хугацаа хожимдуулсны шимтгэл:** Төлбөр төлөх өдрөөс өмнө Заавал төлөх төлбөрийг төлөөгүй бол Заавал төлөх төлбөрийн хэмжээнээс Хугацаа хожимдуулсны шимтгэл сарын хувь /хамгийн багадаа төгрөг/-иар тооцно.
- 2.8. **Картыг системд автоматаар хаах:** Төлбөрийн мэдээлэлд дурдсан Заавал төлөх төлбөрийг Төлбөр төлөх өдрийн дотор бүрэн төлөөгүй 10 хоног болсон тохиолдолд Кредит картын дансыг системд автоматаар хааж зарлага гаргах эрхийг хязгаарлана. Кредит данс системд автоматаар хаагдсан тохиолдолд шимтгэл, хураамж, зээлийн хүү Төлбөр төлөх хүртэл тооцогдсон хэвээр байна.
- 2.9. **Төлбөр төлөх хэлбэр:** Энэхүү гэрээний 3.5-д заасан данснаас сар бүр суутгуулах эсхүл Карт эзэмшигч өөрөө Кредит картын дансанд орлого хийх байдлаар төлнө. Сар бүр Заавал төлөх төлбөрийг суутгуулахаар сонголт хийсэн харилцагч өөрийн хүсэлтээр тухайн сард төлөх нийт Төлбөрийг төлж болно.

- 2.10. **Зээлийн эрхийн зарцуулалт болон хүүгийн төлөлт дараалал:** Зээлийн эргэн төлөлт нь Хугацаа хожимдуулсны шимтгэл, Картын жилийн хураамж, Бэлэн болон Бэлэн бус гүйлгээний шимтгэл, зээлийн хүү, зээлийн үндсэн төлбөр гэсэн дарааллаар төлөгдөнө.
- 2.11. **Зээл олгох хэлбэр:** Кредит карт ашиглан Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээ хийгдсэнээр зээл олгогдсонд тооцно.
- 2.12. **Кредит зээлийг төлөх:** КЭ Кредит зээлийн нийт үлдэгдэл, тооцогдсон хүү шимтгэлийг гэрээний 2.3-т заасан хугацааны дотор төлж зээлийг хаана. КЭ кредит зээлийг хугацаанаас нь өмнө төлж, банкинд мэдэгдэн Кредит лимитийг хаалгаж болно.
- 2.13. Кредит картын бусад шимтгэл, хураамжийн нөхцөлийг ХШЕН-ийн дагуу тооцно. ХШЕН-ийг Банк өөрөө тогтоох, өөрчлөх эрхтэй.

ГУРАВ. КРЕДИТ КАРТЫН ТӨЛБӨР

- 3.1. Банк сар бүрийн 01-ээс 05-ны өдрийн хооронд Кредит КЭ-ийн, Банкны системд бүртгэлтэй цахим шуудангаар Төлбөрийн мэдээлэл хүргүүлэх бөгөөд Кредит КЭ гэрээнд заасны дагуу Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийн хэмжээг, эсхүл Төлбөрийн мэдээлэлд заасан нийт Төлбөрийг тухайн сарын Төлбөр төлөх өдөр багтаан төлнө.
- 3.2. Кредит КЭ нь сар бүр зөвхөн Заавал төлөх төлбөрийг төлсөн бөгөөд Кредит зээлийн хугацааг сунгаж үргэлжлүүлэн ашиглахгүй тохиолдолд Ашигласан зээлийн нийт үлдэгдэл, хүүгийн төлбөр, үйлчилгээний хураамж, гүйлгээний болон хугацаа хожимдуулсан тохиолдолд тооцогдох шимтгэл зэргийг тооцож Кредит зээлийн хугацаа дуусгавар болоход бүрэн төлнө.
- 3.3. Кредит зээлийн хугацаа дуусахад талуудын аль нэг нь гэрээний хугацааг сунгахгүй байх шийдвэр гаргасан бөгөөд гэрээний 3.5, 5.1.8-д заасан харилцах, хадгаламжийн дансан дахь үлдэгдэл нь нийт төлбөрийг төлж хүрэлцэхгүй бол Кредит КЭ-ийн банкинд дахь бусад дансаас Банк үл маргах журмаар суутган төлүүлнэ.
- 3.4. Кредит КЭ нь төгрөгийн картын Төлбөрийг гадаад валютаар төлөхийг хүсвэл Төлбөр хийх тухайн өдрийн Банкны худалдаж авах ханшаар тооцно.
- 3.5. Кредит КЭ нь картын зарцуулалтаа өөрийн ижил төрлийн валютын тоот хадгаламж эсвэл харилцах данснаас автоматаар суутгуулан эргэн төлөлтөө төлж болно.
- 3.6. Гэрээний 3.5-д заасан автомат суутгалын гүйлгээ нь КЭ-ийн эргэн төлөлтөө төлөх эцсийн өдөр байх бөгөөд сар бүр нэг удаа хийгдэнэ.
- 3.7. Гэрээний 3.6-д заасны дагуу суутгал хийгдэх үед холбогдох дансны үлдэгдэл хүрээгүйн улмаас Кредит картын Төлбөр төлөгдөөгүй тохиолдолд уг Төлбөрийг Кредит КЭ өөрөө хариуцан хийнэ. Дансан дахь үлдэгдэл хүрээгүйн улмаас автомат суутгалын гүйлгээ хийгдээгүйгээс болж бодогдсон шимтгэл, хураамж, хүүгийн төлбөрийг Кредит КЭ хариуцна.
- 3.8. Кредит КЭ гэрээний 3.5-д зааснаас бусад хэлбэрээр /Цахим банк, АТМ, Бэлэн бус шилжүүлгийн гүйлгээ, Банкны салбар нэгжид хандаж бэлэн мөнгөөр/ Кредит картын Төлбөр төлөх боломж нь нээлттэй байна.
- 3.9. Банк нь энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг Гэрээний 5.1.8-д заасан барьцаа буюу хууль тогтоомжид заасан журмаар хангуулна. Дээрх үндэслэлээр данснаас хийсэн зарлагын гүйлгээг Кредит КЭ-ийн даалгавраар хийсэн гүйлгээ гэж үзнэ.

ДӨРӨВ. ЗЭЭЛИЙН ЭРХИЙГ ХААХ, ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХ

- 4.1. Банк дараах тохиолдолд зээлийн эрхийн хэмжээг өөрчилж болно. Үүнд:
 - 4.1.1. КЭ-ийн сарын орлого нь нэмэгдсэн тохиолдолд хүсэлтийг нь үндэслэн Банкны журмын дагуу нэмэгдүүлж болно.
 - 4.1.2. Зээлийн хэмжээг доорх тохиолдолд зохих хэмжээнд хүртэл бууруулж болно. Үүнд:
 - 4.1.2.1. Банк нь КЭ-ийн зээлжих чадвар буурсан тухай мэдээлэл авсан тохиолдолд;
 - 4.1.2.2. КЭ-ийн санхүүгийн чадвартай холбоотой бусад нөхцөл байдал бий болсон тохиолдолд.
- 4.2. Кредит картын зарлагын гүйлгээ хийх эрх дараах тохиолдолд түр хаагдана. Үүнд:
 - 4.2.1. Кредит картын Заавал төлөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд зарлагын гүйлгээ гаргах эрх энэхүү гэрээний 2.8-д заасан нөхцөлийн дагуу системд автоматаар хаагдана;
 - 4.2.2. Зарлагын гүйлгээ гарах эрх түр хаагдсаны дараа програмд бодогдсон зээлийн Заавал төлөх төлбөрийн хэмжээгээр төлөлт хийсэн тохиолдолд 1 өдрийн дараа гүйлгээ хийх эрх нээлттэй болно;
 - 4.2.3. КЭ гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд Банкны ажилтан гэрээний үүргээ биелүүлэх хүртэлх хугацаанд түр хугацаагаар картын зарлагын гүйлгээ гарах эрхийг хаана.
 - 4.2.4. Цалингаар баталгаажсан Кредит картын хувьд цалингийн орлого зогссон, Банкны картаар цалин авахаа больсон эсхүл КЭ-ийн хөрөнгийн байдал илэрхий доройтсон гэж Банк үзсэн тохиолдолд;
 - 4.2.5. Хуульд заасан бусад үндэслэл.
- 4.3. Кредит картыг дараах тохиолдолд бүр хаана.
 - 4.3.1. Зээлийн зарцуулалт, хүү, шимтгэл, хураамж бүрэн төлөгдсөний дараа КЭ-ийн хүсэлтээр;
 - 4.3.2. КЭ зээлийн эрхээ 1 жилийн хугацаанд огт ашиглаагүй бол Банкны санаачилгаар.
 - 4.3.3. Кредит зээлийн хугацаа дууссан бөгөөд КЭ зээлийн зарцуулалт, хүү, шимтгэл, хураамж бүрэн төлсний дараа;
- 4.4. Кредит картын зарцуулалтаа төлөөгүй тохиолдолд хүү, шимтгэл нь тэдгээрийн Төлбөрийг бүрэн төлөх өдөр хүртэлх хугацаанд бодогдоно.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Банкны эрх

- 5.1.1. Банк нь 4-р зүйлд заасан үндэслэлээр зээлийн эрхийн хэмжээг багасгах, зарлагын гүйлгээ гарах эрхийг түр хаах, бүр хаах эрхтэй;

- 5.1.2. Шаардлагатай тохиолдолд Кредит картын Төлбөрийг КЭ-ийн Банкинд дахь данснаас суутгах болон ирээдүйд карт эзэмшигчийн нэр дээр нээгдэх данснаас үл маргах журмаар суутган авах эрхтэй;
- 5.1.3. Хадгаламж барьцаалсан Кредит карт хугацаа хэтэрсэн бол хадгаламжийн данснаас хэсэгчлэн суутгаж картын дансанд шилжүүлж Кредит картын өрийг барагдуулах бөгөөд барьцааны дүнд харгалзуулан Кредит зээлийн хэмжээг бууруулах эрхтэй;
- 5.1.4. Гэрээний 5.1.3-д заасан нөхцөлөөр хугацаатай хадгаламжаас суутгал хийсэн тохиолдолд журмын дагуу хугацаатай хадгаламжийн хүү хугацаагүй хадгаламжийн хүүний 50 хувиар тооцогдоно.
- 5.1.5. Картаар сэжигтэй гүйлгээ гарсан тохиолдолд КЭ-тэй /холбоо барих утас, имэйлээр/ холбогдож чадаагүй бол Банкны зүгээс картын зарлагын гүйлгээг түр хугацаагаар хаах эрхтэй;
- 5.1.6. Луйврын гүйлгээний эрсдэлээс сэргийлэх зорилгоор Банк картаар гарсан сэжигтэй гүйлгээг хянаж, КЭ-тэй холбогдож баталгаажуулах эрхтэй;
- 5.1.7. КЭ нь энэхүү гэрээг зөрчсөн тохиолдолд Банк картын гүйлгээг зогсоох эрхтэй;
- 5.1.8. Хэрэв КЭ хадгаламж эсвэл цалин буюу цалингийн данс барьцаалан Кредит карт нээлгэсэн бол Банк тоот дансыг хяналтдаа авч барьцаалсан гэж тооцох бөгөөд Кредит зээлийг төлүүлэхэд шаардлагатай дүнгээр хадгаламжийн дансны зарлагын гүйлгээг зогсооно.
- 5.1.9. КЭ Заавал төлөх төлбөр, Кредит зээлийн нийт үлдэгдлийг төлөх зэрэг үүргээ биелүүлээгүй бол Банк энэ гэрээний 5.1.8-д заасан данснаас үүргийн зөрчлийг үл маргах журмаар шаардлагаа хангуулах эрхтэй. Барьцаалагдсан хадгаламжийн дансыг Банк холбогдох дүнгээр битүүмжилнэ;
- 5.1.10. Энэхүү гэрээний 4.2, 5.1.9-д заасан нөхцөл үүссэн буюу гэрээний үүргийн зөрчил үүссэн тохиолдолд банк барьцаалсан данс болон КЭ-ийн бусад данснаас гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хэмжээгээр суутгал хийх эрхтэй;
- 5.1.11. Монгол Улсад байрлах АТМ-д хураагдсан картыг тухайн өдрөөс хойш 3 сарын хугацаанд банкнаас аваагүй бол картыг хүчингүй болгох;
- 5.1.12. КЭ нь картаар хийгдсэн гүйлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухайгаа гэрээний 5.3.1-д заасан хугацааны дотор Банкинд хүсэлт ирүүлээгүй буюу хугацаа хоцорч хүсэлт ирүүлсэн бол хүсэлтийг хүлээн авахгүй байх эрхтэй;
- 5.1.13. КЭ хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дутуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид “Маргаантай гүйлгээ” гэх)-г шийдвэрлэхийн тулд маргаантай гүйлгээний дүнгээр дансанд түр хаалт тавих;
- 5.1.14. КЭ захиалсан картаа Шуудангийн үйлчилгээгээр хүлээн авахаар ХШЕН-д заасан хураамжийг төлсөн боловч шууданг хүлээн авах хаягтаа байгаагүй, эсвэл хаягаа алдаатай бүртгүүлсэнээс болж картаа хүлээн авч чадаагүй бол шимтгэлийг банк буцаан олгохгүй байх;
- 5.1.15. КЭ-ийн буруугаас Банк, ҮБ болон бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол КЭ-ийн картын болон бусад данснаас үл маргах журмаар суутган авах, дансан дахь үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
- 5.1.16. Банк гэрээнд өөрчлөлт оруулах талаар карт эзэмшигчдэд хуанлийн 30 /гуч/ хоногийн өмнө банкны холбогдох суваг/вебсайт, интернэт банк/-р мэдээлснээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд карт эзэмшигч заасан хугацаанд гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 5.1.17. КЭ-ийн картаараа хийсэн төлбөр, тооцоог Монгол улсын картын сүлжээнд хийгдсэн гүйлгээний хувьд тухай бүр, Олон улсын картын сүлжээнд хийгдсэн бол гүйлгээ хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор холбогдох данснаас нь суутган авч байх.
- 5.1.18. Гэрээний 2.3-д заасан Кредит зээлийн хугацаа дууссан бол КЭ-ээр шимтгэл, хураамж кредит зээлийн хүү, кредит зээлийн дүнг хугацаа дууссан даруйд бүрэн төлүүлж Кредит зээлийг хаах.

5.2. Банкны үүрэг

- 5.2.1. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор Банк Кредит картын зээлийн лимит нээнэ;
- 5.2.2. Банкны зүгээс картыг хаасан тохиолдолд утсаар болон имэйл хаяг руу карт эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй;
- 5.2.3. Банк Кредит карттай холбоотой ХШЕН өөрчлөгдөх үед Банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй;
- 5.2.4. Банк нь Монголбанкны дүрэм, журамд заасны дагуу бусад зээлийн адил Монголбанкны зээлийн мэдээллийн санд карт эзэмшигчийн Кредит картын зээлийн ангиллыг тухай бүрд нь бүртгүүлнэ;
- 5.2.5. Кредит КЭ-д Кредит картыг хүлээлгэн өгөх, идэвхжүүлэх, гэрээний нөхцөлийг тайлбарлах, хэрэглэх заавраар хангана;
- 5.2.6. Кредит картын Төлбөрийн мэдээллийг Кредит КЭ-ийн Банкны системд бүртгэлтэй цахим хаягаар хүргүүлнэ;
- 5.2.7. Кредит КЭ-ийн хувийн болон гүйлгээний талаарх мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, хуульд зааснаас бусад үндэслэлээр задруулахгүй;
- 5.2.8. Банкны АТМ болон бусад терминал дээр болон системд гарсан техникийн саатлын улмаас Кредит КЭ-д мөнгийг олгоогүй нь тогтоогдсон тохиолдолд мөнгөн дүнг холбогдох журмын дагуу харилцагчийн картын дансанд буцаан олгох үүрэгтэй;
- 5.2.9. КЭ дэд карт нээлгэх, алдаж үрэгдүүлсэн, гэмтсэн карт дахин авах талаар гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- 5.2.10. Бусад банк болон гадаадын банкны сүлжээнд гарсан төлбөр тооцоотой холбоотой маргааныг Монголбанкны төлбөрийн картын журам, Виза интернэйшнл байгууллага болон бусад картын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журам, “Улаанбаатар хотын банкны картын маргаантай гүйлгээг шалгах, шийдвэрлэх журам”, холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 5.2.11. Банк нь картаар гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг /цахим шуудангаар г.м/ үнэ төлбөргүй КЭ-д мэдэгдэх нэгээс доошгүй суваг үйлчилгээний нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх.
- 5.2.12. Монгол улсын картын сүлжээнд Картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар КЭ банкинд хүсэлт гаргасан бол Банк АТМ, ПОБ -ын гүйлгээний хүсэлтийн хариуг Карт хүлээн авагч банкинд бүртгүүлсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг ажлын 10 хоногийн дотор,

Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг хуанлийн 30-45 хоногийн дотор КЭ-д мэдэгдэх;

- 5.2.13. Энэхүү гэрээний 5.2.12-д заасны дагуу хүсэлтийн хариуг КЭ хүлээн зөвшөөрөхгүй бол гэрээний 5.2.10-д заасан журам зааврын дагуу шийдвэрлэнэ.

5.3. Карт эзэмшигчийн эрх

- 5.3.1. Монгол улсын картын сүлжээнд картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар АТМ, ПОБ -ын гүйлгээ бол гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 40 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээ бол ажлын 60 хоногийн дотор, Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ-ын гүйлгээ бол хуанлийн 75 хоног, ПОС-ын гүйлгээ бол хуанлийн 120 хоногийн дотор Банканд биеер ирж бичгээр эсвэл Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн лавлах дугаар /1800-1800/-т хандаж хүсэлт гаргах;
- 5.3.2. Кредит картын үлдэгдэл болон гүйлгээний мэдээллийг Банкаас гаргуулах;
- 5.3.3. Кредит картын зээлийн лимитийн хэмжээг нэмэгдүүлэх, хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргах;
- 5.3.4. КЭ нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах эрхтэй.
- 5.3.5. Карт гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн бол карт нөхөж авах, ПИН кодоо мартсан бол шинээр авах хүсэлтийг Банканд гаргаж, шийдвэрлүүлэх;

5.4. Карт эзэмшигчийн үүрэг

- 5.4.1. КЭ нь Кредит зээлийн хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Банкинд мэдэгдэх үүрэгтэй;
- 5.4.2. КЭ нь өөрийн карт болон бүх дэд Кредит картын зарцуулалт, хүү, шимтгэл, хураамжийг бүрэн хариуцаж, зарцуулалтыг Төлбөр төлөх өдрөөс өмнө төлөх үүрэгтэй.
- 5.4.3. КЭ Кредит картанд үүссэн зээлийн зарцуулалт, түүний хүү, шимтгэл, хураамж болон ХШЕН-д заасан шимтгэл хураамжийг гэрээнд заагдсан хугацаа, нөхцөлийн дагуу төлөх үүрэгтэй.
- 5.4.4. КЭ-ийн талаарх мэдээлэл өөрчлөгдөх бүрд Банканд мэдэгдэж шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
- 5.4.5. Аливаа шалтгаанаас хамааран Төлбөрийн мэдээлэл КЭ-ийн цахим хаягт очоогүй бол энэ нь Төлбөр төлөх үүргээ биелүүлэхгүй байх, хүү, шимтгэлээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд картын хэрэглээгээ Төлбөрийн мэдээллээс үл хамааран шалгаж Төлбөрийг Төлбөр төлөх өдөрт багтаан төлөх үүрэгтэй.
- 5.4.6. Дансны гүйлгээний хуулгыг тогтмол шалгаж, маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй ямар нэгэн гүйлгээ хийгдсэн тохиолдолд Гэрээний 5.3.1-д заасан хугацааны дотор банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүй эсвэл заасан хонгоос хойш мэдээлсний улмаас үүссэн хохирлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.7. КЭ болон Дэд КЭ нь картын нууцлал болох картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, картын ПИН код, интернет ПИН код, Картын соронзон туузанд бичигдсэн мэдээллийн нууцлалыг нарийн чанд хадгалах, бусдад мэдэгдэхгүй байх, картаа бусдад ашиглуулахгүй байх үүрэгтэй бөгөөд картын нууцлалаа алдсанаас үүсэх аливаа эрсдэл, хохирол зардлыг бүрэн хариуцах;
- 5.4.8. Өөрийн карт буюу пин кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн, картын пин код, картын мэдээллийг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн /1800-1800/ дугаарын утсанд мэдэгдэж хаалгах эсвэл Цахим банкны үйлчилгээгээр нэн даруй картаа өөрөө хаах бөгөөд эдгээр үйлдлийг хийгээгүйн улмаас үүсэх хохирлыг өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.9. Банкны харилцагчийн мэдээллийн төвөөр буюу зайнаас үйлчилгээ авсантай холбоотой үүссэн аливаа маргаан, хохирол зардлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.10. Шуудангийн үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авахдаа дугуйны битүүмжийг сайтар шалган авах ёстой бөгөөд битүүмж задарсан бол картыг хүлээн авахгүй байж банкинд энэ талаар нэн даруй мэдэгдэх;
- 5.4.11. Шуудан үйлчилгээг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд ашиглах;
- 5.4.12. Шуудан үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авсан бол өөрийн бүртгэлтэй Цахим банк үйлчилгээгээр картыг идэвхжүүлэх;
- 5.4.13. Дотоодын болон олон улсын Кредит картын хувьд Монгол улсын төлбөрийн сүлжээнд КЭ-ийн хийсэн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Банкны журам, заавар, Монолбанкны журам, зааврын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд КЭ-д хохирол учирхаар шийдвэрлэгдсэн бол хохирлыг бүрэн хариуцах;
- 5.4.14. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Виза интернэйшл байгууллагын холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд Маргаан КЭ-ийн эсрэг шийдвэрлэгдсэн бол хохирол, үр дагаварыг бүрэн хариуцах;
- 5.4.15. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшл байгууллага болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын сүлжээнд КЭ-ийн хийсэн гүйлгээ, тухайн гүйлгээний валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болох ханшийн зөрүү, Виза интернэйшл байгууллага болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын зүгээс ХШЕН-өөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг карт эзэмшигч бүрэн хариуцах;
- 5.4.16. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшл байгууллагын сүлжээнд хийсэн бүх гүйлгээ нь эхлээд УБХБ-ны бэлэн бус ам.доллар зарах ханшаар хөрвөх бөгөөд картын гүйлгээний валют нь төгрөг, ам.доллараас өөр валют бол ам.доллар тухайн гуравдагч валюттай харьцах ханш нь Виза интернэйшл байгууллагын ханш байх бөгөөд энэхүү ханшын зөрүүг харилцагч бүрэн хариуцах үүрэгтэй;
- 5.4.17. Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад КЭ нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан зардлыг бүрэн хариуцах;
- 5.4.18. Гэрээний 2.3-д заасан Кредит зээлийн хугацаа дууссан бол КЭ шимтгэл, хураамж кредит зээлийн хүү, кредит зээлийн дүнг хугацаа дуусахаас өмнө бүрэн төлж барагдуулна.

5.5. Хариуцлага

- 5.5.1. КЭ өөрийн картын дугаар, нэр, хүчинтэй хугацаа, CVV код, ПИН код болон интернэт худалдаанд ашиглагдах интернэт ПИН кодыг бусдад алдсаны улмаас хийгдсэн луйврын гүйлгээний хохирол үр дагварыг бүрэн хариуцна.
- 5.5.2. КЭ картаа алдсан, бусдад картаа шилжүүлсний улмаас хийгдсэн Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээний үр дагвар, хохиролыг бүрэн хариуцна.
- 5.5.3. КЭ өөрийн Кредит данс дээр олгосон Дэд картын бүх зарлагын гүйлгээ, хүү, шимтгэл, хураамжыг бүрэн хариуцна.
- 5.5.4. КЭ зөвшөөрөлгүй хийгдсэн гэх гүйлгээг энэхүү гэрээнд заасан хугацааны дотор Банкинд мэдэгдээгүйгээс үүдэн гарах эрсдлийг бүрэн хариуцна.
- 5.5.5. Олон улсад ашиглагдах Кредит КЭ-ийн Виза интернэйшл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн гүйлгээтэй холбоотой асуудлыг Банк харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох журмын дагуу харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирол, үр дагаварыг бүрэн хариуцна;
- 5.5.6. Дотоодод эсвэл олон улсад ашиглагдах Кредит картын хувьд дотоодын банкны сүлжээнд гаргасан Төлбөрийн картын маргаантай холбоотой асуудлыг харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох банкуудтай харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирлыг бүрэн хариуцна;
- 5.5.7. Картын хэвийн тасралтгүй найдвартай ажиллагааг Банк хариуцна;
- 5.5.8. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Банк хариуцлага хүлээхгүй.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 6.2. Картаар хийгдсэн маргаантай эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа аливаа гүйлгээг дотоодын банкны сүлжээнд гарсан маргаан бол Улаанбаатар хотын банкны болон Монголбанкны гаргасан журам заавраар, олон улсын сүлжээнд гарсан маргаан бол Виза интернэйшл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Олон улсын сүлжээнд хийсэн гүйлгээний маргааны хувьд Виза интернэйшл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэсэн арбитрын шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- 6.4. Талуудын хооронд үүссэн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй, буруутай тал нь тогтоогдоогүй байхад, Банкны нэр хүндэд халдах, гутаах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээ тараахыг хориглоно. Үүний улмаас Банкинд учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.
- 6.5. Энэ гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын хуулийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.6. Талуудын хооронд үүсэх маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. Энэ заалт гэрээний 6.3-т заасан маргаанд хамаарахгүй.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1. Талууд гэрээний зохицуулалт, бүтээгдэхүүний нөхцөлтэй бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн бөгөөд сайн дурын үндсэн дээр энэхүү гэрээг байгуулсан болно.
- 7.2. Кредит зээлд данс дахь хөрөнгө барьцаалсан бол Хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг, бусад төрлийн хөдлөх хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бол холбогдох барьцааны гэрээг тус тус мөрдөнө.
- 7.3. Энэ гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудал Монгол улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 7.4. Энэ гэрээг 2 эх хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарж баталгаажуулснаар, хүчин төгөлдөр болно.
- 7.5. Энэ гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд бичгээр үйлдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийн гэрээ нь энэхүү гэрээний 7.4-т заасан нөхцөл хангагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 7.6. Энэхүү гэрээний хавсралтаар үйлдэгдэх Барьцааны гэрээ, Батлан даалтын гэрээ, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд эдгээр гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл Кредит картын гэрээг зөрчсөнтэй адилтган тооцно.
- 7.7. Энэ гэрээний дагуу эзэмшиж буй картаар хийсэн гүйлгээний хувьд өөрийн картын мэдээллийг цахим гүйлгээний талбарт оруулсан; картыг ПОС, ПОБ, АТМ төмөрөмжд уншуулсан; мөн гүйлгээг хийхэд Картын ПИН код, эсхүл Интернэт ПИН код шаардсан бол тэдгээр кодыг оруулсан зэргийг холбогдох гүйлгээний баримтад зурсан гарын үсэг зурсантай адилтгаж тооцно.
- 7.8. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсноос гэрээнд заасан үндэслэлээр цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 7.9. Энэ гэрээг байгуулах өдрийн байдлаар мөрдөгдөж буй Картын үйлчилгээний ХШЕН-ийг гэрээний хавсралтад тусгасан бөгөөд уг нөхцөлийг Банк энэ гэрээнд заасан журмаар өөрчилж болно. КЭ нь энэхүү нөхцөлийг гэрээний Хавсралт №1-д дурдсан ХШЕН-тэй танилцаж зөвшөөрсний үндсэн дээр гэрээ байгуулсан болно.

Нэмэлт үйлчилгээ: Автомат суутгал /Энэ хэсгийг бөглөснөөр кредит картын суутгал автоматаар хийгдэхийг зөвшөөрсөнд тооцно. Суутгал хийх өдөр доорх дансны үлдэгдэл хурьцэхгүй бол суутгал хийгдэхгүй болохыг анхаарна уу./

Сар бүрийн зарцуулалтаа автоматаар данснаасаа суутгуулах эсэх: Гийм Үгүй

Суутгал хийх дансны дугаар:

Данс эзэмшигчийн нэр:

Эргэн төлөх дүн: Заавал төлөх төлбөр

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гэрээний нөхцлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон картын үйлчилгээний хүү, шимтгэлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.

Банкийг төлөөлж:
Харилцагчийн менежер/Лавлагааны ажилтан:

Гарын үсэг: _____

Салбар нэгжийн
Захирал: _____
Гарын үсэг, тамга: _____

Кредит карт эзэмшигч:

Нэр: _____

Гарын үсэг: _____

Регистр №: _____

КРЕДИТ КАРТЫН ХҮҮ, ШИМТГЭЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нөхцөл		Дотоодын карт	Олон улсын карт
Кредит картын дансны валют			
Жилийн хураамж /Картын хүчинтэй хугацаанд жил бүр суутган авна/			
Карт нөхөн авах / алдсан, гээсэн, гэмтээсэн/			
6 цагийн дотор карт хэвлүүлэх үйлчилгээний хураамж			
Картын ПИН код солих	УБХБ болон ХХБ-ны АТМ		
	Гэрээт банкуудын АТМ		
	УБХБ-ны салбар		
Зээлийн хүү	Бэлэн бус гүйлгээ		
	Бэлэн гүйлгээ		
Заавал төлөх төлбөрийн доод хэмжээ			
Заавал төлөх төлбөрийг төлөх өдөр			
Хугацаа хэтрүүлсний шимтгэл <i>/заавал төлөх төлбөрийг төлөх ёстой хугацаанд багтаж төлөөгүй бол тооцно/</i>			
Өдрийн гүйлгэний хязгаар	АТМ болон Банкны салбараас картаар бэлэн мөнгө авах	Тоо	
		Дүн	
	Худалдан авалт хийх	Тоо	
		Дүн	
Картын ПИН код буруу хийх боломж	Тоо		
Кредит зээлийн лимитээс Бэлнээр зарцуулах хязгаар			
АТМ-р үлдэгдэл шалгах	Олон улсын АТМ-ээр		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээр		
	Гэрээт банкны АТМ-ээр		
	Бусад банкны АТМ		
АТМ –ээс бэлэн мөнгө авах	Олон улсын АТМ-ээс		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээс		
	Гэрээт банкны АТМ-ээс		
	Бусад банкны АТМ-ээс		
Банкны Салбар, Тооцооны төвөөс бэлэн мөнгө авах	Гадаадын банкны салбараас		
	УБХБ-ны салбараас		
	ХХБ-ны салбараас		
	Гэрээт банкны салбараас		
	Бусад банкны АТМ-ээс		

КРЕДИТ КАРТЫН ГЭРЭЭ

/Дотоодын кредит картыг Олон улсын Виза картад шилжүүлэх/

..... оны сарын өдөр

Дугаар №.....

Улаанбаатар хот

Энэхүү **КРЕДИТ КАРТЫН ГЭРЭЭ** /цаашид “Гэрээ” гэнэ/-г Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Улаанбаатар хотын банк, Монголбанкны холбогдох журам, дүрмийг үндэслэн,

Нэг талаас Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 15160, Д.Сүхбаатарын талбай 11 хаягт байрлах "УЛААНБААТАР ХОТЫН БАНК" /цаашид “**Банк**” гэх/,

Нөгөө талаас _____ тоот хаягт байрлах _____ тоот регистрийн дугаартай _____ овогтой _____ (цаашид Карт эзэмшигч буюу “**КЭ**” гэх) (хамтад нь “**Талууд**” гэх) нарын хооронд харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээ нь Банк Кредит КЭ-д түүний хэрэглээнд зориулан тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаа, хүү, шимтгэл хураамж, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр зээлжих эрх нээх, Кредит КЭ нь уг нөхцөлийн дагуу Ашигласан зээлтэй холбогдуулан шимтгэл, хураамж, Ашигласан зээлийн хүү, зарцуулсан зээлийн дүн зэрэг нийт төлбөрийг эргэн төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Энэ гэрээнд хэрэглэгдэх дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.2.1 “**Төлбөрийн карт**” (цаашид “карт” гэх) гэж “төлбөрийн карт” гэж олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкны шаардлагыг нэгэн зэрэг, эсхүл аль нэгийг нь хангасан карт эзэмшигч (цаашид “КЭ” гэх)-д төлбөр хийх боломж олгодог төлбөрийн хэрэгслийг;
- 1.2.2 “**Картын ПИН код**” гэж төлбөрийн КЭ-ийг картын жинхэнэ эзэмшигч гэдгийг нотлох 4-6 оронтой нууц кодыг;
- 1.2.3 “**CVV код**” гэж картын бэлдэцийн ар хэсэгт хэвлэгдсэн, интернэт худалдан авалт хийхэд ашигладаг 3 оронтой тоог;
- 1.2.4 “**Интернет ПИН код**” гэж КЭ өөрийн картаа ашиглан интернет худалдан авалт хийхэд тухайн КЭ гэдгийг нотлох 4 оронтой нууц дугаарыг;
- 1.2.5 “**Үйлчилгээний байгууллага**” (цаашид “ҮБ” гэх) гэж бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг төлбөрийн картаар хүлээн авч үйлчлэх талаар Виза интернэшнл болон бусад төлбөрийн картаар үйлчлэгч байгууллагын гишүүн аль нэгэн банк, санхүүгийн байгууллагатай гэрээ байгуулан төлбөр хүлээн авч байгаа байгууллага, хувь хүнийг;
- 1.2.6 “**Хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл**” (цаашид “ХШЕН” гэх) гэж Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөрдөгдөх хүү, шимтгэл, хураамжийн хувь хэмжээг тогтоосон, банкны www.ubcbank.mn цахим хуудсанд нийтэлсэн үйлчлүүлэгчиддээ мэдэгдсэн баримт бичигийг;
- 1.2.7 “**Картын жилийн хураамж**” гэж ХШЕН-д заасан карт ашигласны төлбөрт жил бүр төлөх төлбөрийг;
- 1.2.8 “**Бэлэн мөнгөний шимтгэл**” гэж Банк болон бусад гадаад, дотоодын арилжааны банк, санхүүгийн байгууллагын салбар болон АТМ-ээс бэлэн мөнгө авсан дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
- 1.2.9 “**Шилжүүлгийн гүйлгээний шимтгэл**” гэж Картын данснаас бэлэн бусаар шилжүүлсэн гүйлгээний дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
- 1.2.10 “**Картын өдрийн зарцуулалтын лимит**” гэж ХШЕН-д тогтоосон Картаар хийгдэх гүйлгээний өдрийн зарцуулалтын дүн, тооны хязгаарыг;
- 1.2.11 “**Картын нэмэлт үйлчилгээний шимтгэл**” гэж Карт дахин захиалах, дэд карт захиалах, Картын ПИН код солих, картын Интернет ПИН кодыг идэвхжүүлэх, картын үлдэгдэл шалгах болон бусад үйлчилгээнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
- 1.2.12 “**Кредит карт**” гэж Банкны баталсан зээлийн эрхийн хүрээнд зарцуулалт хийн, ХШЕН-д заасан хугацаанд хүү, шимтгэлтэйгээр эргэн төлөх нөхцөлтэй дотоодод болон олон улсад ашиглагдах боломжтой Улаанбаатар хотын банкны төлбөрийн картыг;
- 1.2.13 “**Кредит картын зээлийн лимит**” гэж харилцагчийн хүсэлтийг үндэслэн Банкнаас тогтоосон Кредит картын зээлийн ашиглах боломжит дээд хэмжээг;
- 1.2.14 “**Кредит зээлийн хугацаа**” (цаашид “Зээлийн хугацаа” гэх) гэж Банкнаас тогтоосон кредит зээлийн лимитийн хугацааг;
- 1.2.15 “**Ашигласан зээл**” гэж Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээ хэлбэрээр зарцуулсан Кредит картын зээлийн хэмжээг;
- 1.2.16 “**Бэлэн зарлага**” гэж Банк болон бусад банкаар дамжуулан картын дансаар хийгдэх дараах зарлагын, шилжүүлгийн болон төлбөрийн гүйлгээг ойлгоно. Үүнд:
 - АТМ-р хийгдэх зарлагын гүйлгээ;
 - Банкны салбар нэгжүүдэд хийгдэх зарлагын гүйлгээ;
 - АТМ, Салбар нэгж, Цахим банк үйлчилгээгээр хийгдэх шилжүүлгийн гүйлгээ;
 - АТМ, Салбар нэгж, Цахим банк үйлчилгээгээр хийгдэх төлбөрийн гүйлгээ.
- 1.2.17 “**Бэлэн бус гүйлгээ**” гэж Кредит карт болон Кредит картын дугаар ашиглан бэлэн бус төлбөр тооцоогоор бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах гүйлгээ;
- 1.2.18 “**Төлбөрийн мэдээлэл**” гэж тухайн Төлбөрийн цикл Банкны хүлээн авсан, КЭ-ийн картаар хийгдсэн гүйлгээ, төлөх ёстой хураамж, хүү, шимтгэл, төлбөр, Заавал төлөх төлбөр, түүнийг төлөх хугацааны талаар багтаасан мэдээллийн жагсаалт бүхий Карт эзэмшигчид цахим байдлаар эсвэл цаасаар хэвлэн өгсөн баримтыг;
- 1.2.19 “**Төлбөрийн цикл**” гэж тухайн сарын Төлбөрийн мэдээлэл гаргах өдрөөс дараа сарын Төлбөрийн мэдээлэл гаргах өдөр хүртэл хугацааг;
- 1.2.20 “**Төлбөрийн мэдээлэл гаргах өдөр**” гэж тухайн Төлбөрийн цикл хамаарах бүхий л гүйлгээтэй холбоотой мэдээллийг багцлан бэлдэж, хэвлэн гаргахад бэлэн болгох ажлын өдрийг;

- 1.2.21 **“Төлбөр”** гэж тухайн Төлбөрийн циклд картаар хийгдсэн худалдан авалт, бэлэн мөнгө, шилжүүлгийн гүйлгээ, зээлийн лимитийн хэтэрсэн дүн болон Банкинд төлөх хураамж, хүү, шимтгэл зэргийн нийлбэр мөнгөн дүнг;
- 1.2.22 **“Заавал төлөх төлбөр”** гэж Төлбөр төлөх хугацаанд багтаан заавал төлөх ёстой, тухайн Төлбөрийн циклд Кредит картаар зарцуулсан нийт дүнгийн ХШЕН-д заасан хувь, тухайн Төлбөрийн циклд хамаарах нийт хураамж, хүү, шимтгэл, зээлийн лимитийн хэтэрсэн дүн болон өмнөх Төлбөрийн циклд төлөгдөөгүй Заавал төлөх төлбөр зэргийн нийлбэр мөнгөн дүнг;
- 1.2.23 **“Төлбөр төлөх хугацаа”** гэж Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийг төлөх өдөр хүртэлх хугацааг;
- 1.2.24 **“Төлбөр төлөх өдөр”** гэж Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийг төлөх өдрийг;
- 1.2.25 **“Хугацаа хожимдуулсны шимтгэл”** гэж Төлбөрийн мэдээлэлд заасан заавал төлөх Төлбөрийг Төлбөрийн мэдээлэлд заасан хугацаанд төлөөгүй эсхүл дутуу төлсөн сар тутамд Ашигласан зээлийн хэмжээнээс үл хамааран Банкинд төлөх төгрөгөөр илэрхийлэгдэх мөнгөн дүнг;
- 1.2.26 **“Цахим банк үйлчилгээ”** (цаашид “Цахим банк” гэх) гэж харилцагч мобайл, интернэт сувгаар дамжуулан авч буй банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх үйлчилгээг.
- 1.2.27 **“Карт ашиглагдах хэлбэр”** гэж Contactless буюу зайнаас картыг уншуулж ашиглах, EMV chip технологи буюу ЧИП-ээр картыг уншуулж ашиглах, Magnetic Stripe буюу соронзон туузаар картыг уншуулж ашиглах, Карт дээрх мэдээллээ ашиглан интернэт үйлчилгээний байгууллагаар картыг уншуулж ашиглахыг ойлгоно.
- 1.2.28 **“ПОС төхөөрөмж”** (цаашид “ПОС” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар ҮБ-д байршуулсан, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.29 **“МПОС төхөөрөмж”** гэж ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.30 **“ПОБ төхөөрөмж”** гэж карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.2.31 **“Автомат теллер машин”** (цаашид “АТМ” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
- 1.3 Кредит КЭ нь дараах зөвшөөрлийг Банкинд энэхүү гэрээгээр олгосон бөгөөд Банк дахин аливаа хэлбэрээр Кредит КЭ-ээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагагүй болно. Үүнд:

- 1.3.1 Картын системийн доголдол, техникийн саатлаас үүдэн Кредит картад давхар эсвэл илүү мөнгөн дүнгээр гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн алдаатай гүйлгээг залруулах зорилгоор давхар болон илүү мөнгөн дүнгээр хийгдсэн мөнгөн хөрөнгийг Кредит картаас үл маргах журмаар суутган авах, эсвэл дансанд битүүмж хийхийг КЭ үүгээр Банкинд зөвшөөрсөн болно.
- 1.3.2 Кредит картын **Заавал төлөх төлбөрийг** Төлбөр төлөх хугацаанд багтаан бүрэн төлөөгүй хугацаа хожимдуулсан тохиолдолд хугацаа хожимдуулсан дүнг энэхүү гэрээний 5.1.8-д заасан данснаас, тухайн дансан дахь үлдэгдэл нь Төлбөрийг төлж хүрэлцэхгүй бол Кредит КЭ-ийн бусад дансдаас банк үл маргах журмаар суутган төлүүлнэ;
- 1.4 КЭ нь энэхүү гэрээг байгуулахын өмнө Банктай _____ дугаартай Дотоодын кредит карт эзэмших гэрээ байгуулан Кредит карт эзэмшиж байсан бөгөөд КЭ уг кредит картыг олон улсад ашиглагдах кредит картаар солих хүсэлт гаргасны дагуу Кредит зээлийн харилцааг зогсоохгүйгээр зөвхөн картыг солих, картыг олон улсын гүйлгээ хийх боломжтой болгох зорилгоор энэхүү Кредит карт эзэмших гэрээг шинэчилэн байгуулсан болно. Үүнтэй холбоотойгоор энэ гэрээг байгуулахаас өмнө хугацаанд хамаарах Кредит зээлийн харилцааг Дотоодын кредит карт эзэмших гэрээний дагуу, байгуулснаас хойшхи харилцааг энэ гэрээний дагуу тус тус зохицуулна.
- 1.5 Энэ гэрээний 1.4-т заасантай холбоотойгоор энэ гэрээний 2.1, 2.3 дахь хэсэгт тусгасан Кредит зээлийн лимит, Зээлийн хугацаа зэргийг Дотоодын кредит карт эзэмших гэрээнд заасан нөхцөлөөр тусгасан болно.

ХОЁР. КРЕДИТ КАРТЫН НӨХЦӨЛ

- 2.1. **Кредит зээлийн лимит:**(.....) төгрөг
тоогоор үсгээр
- 2.2. **Кредит картын зориулалт:** Сар тутмын санхүүгийн хэрэгцээ
- 2.3. **Зээлийн хугацаа:** (.....) сар
- 2.4. **Бэлэн зарлагын хүү:** Жилийн (.....) хувь байна. Банк хүүг тооцоходоо Бэлэн зарлага хийсэн дүнг жилийн хүүгээр үржүүлж, 365 хоногт харьцуулах ба бэлэн зарлагын гүйлгээ хийсэн өдрөөс эхлэн эргэн төлөх өдөр хүртэлх хугацаанд тооцно.
- 2.5. **Бэлэн бус гүйлгээний хүү:** Жилийн (.....) хувь байна. Банк хүүг тооцоходоо Бэлэн бус гүйлгээний дүнг жилийн хүүгээр үржүүлж, 365 хоногт харьцуулах ба гэрээнд заасан Төлбөр төлөх өдрөөс эхлэн тооцогдох ба тухайн Төлбөрийг бүрэн төлсөн өдөр хүртэл тооцогдоно.
- 2.6. **Заавал төлөх төлбөр:** тухайн сарын нийт зарцуулсан Төлбөрөөс Төлбөр төлөх хугацааны өмнө заавал төлсөн байхаар ХШЕН-д заасан дүн.
- 2.7. **Хугацаа хожимдуулсны шимтгэл:** Төлбөр төлөх өдрөөс өмнө Заавал төлөх төлбөрийг төлөөгүй бол Заавал төлөх төлбөрийн хэмжээнээс Хугацаа хожимдуулсны шимтгэл сарын хувь /хамгийн багадаа төгрөг/-иар тооцно.
- 2.8. **Картыг системд автоматаар хаах:** Төлбөрийн мэдээлэлд дурдсан Заавал төлөх төлбөрийг Төлбөр төлөх өдрийн дотор бүрэн төлөөгүй **10** хоног болсон тохиолдолд Кредит картын дансыг системд автоматаар хааж зарлага гаргах эрхийг хязгаарлана. Кредит данс системд автоматаар хаагдсан тохиолдолд шимтгэл, хураамж, зээлийн хүү Төлбөр төлөх хүртэл тооцогдсон хэвээр байна.
- 2.9. **Төлбөр төлөх хэлбэр:** Энэхүү гэрээний 3.5-д заасан данснаас сар бүр суутгуулах эсхүл Карт эзэмшигч өөрөө Кредит картын дансанд орлого хийх байдлаар төлнө. Сар бүр Заавал төлөх төлбөрийг суутгуулахаар сонголт хийсэн харилцагч өөрийн хүсэлтээр тухайн сард төлөх нийт Төлбөрийг төлж болно.
- 2.10. **Зээлийн эрхийн зарцуулалт болон хүүгийн төлөлт дараалал:** Зээлийн эргэн төлөлт нь Хугацаа хожимдуулсны шимтгэл, Картын жилийн хураамж, Бэлэн болон Бэлэн бус гүйлгээний шимтгэл, зээлийн хүү, зээлийн үндсэн төлбөр гэсэн дарааллаар төлөгдөнө.
- 2.11. **Зээл олгох хэлбэр:** Кредит карт ашиглан Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээ хийгдсэнээр зээл олгогдсонд тооцно.
- 2.12. **Кредит зээлийг төлөх:** КЭ Кредит зээлийн нийт үлдэгдэл, тооцогдсон хүү шимтгэлийг гэрээний 2.3-т заасан хугацааны дотор төлж зээлийг хаана. КЭ кредит зээлийг хугацаанаас нь өмнө төлж, банкинд мэдэгдэн Кредит лимитийг хаалгаж болно.
- 2.13. Кредит картын бусад шимтгэл, хураамжийн нөхцөлийг ХШЕН-ийн дагуу тооцно. ХШЕН-ийг Банк өөрөө тогтоох, өөрчлөх эрхтэй.

ГУРАВ. КРЕДИТ КАРТЫН ТӨЛБӨР

- 3.1. Банк сар бүрийн 01-ээс 05-ны өдрийн хооронд Кредит КЭ-ийн, Банкны системд бүртгэлтэй цахим шуудангаар Төлбөрийн мэдээлэл хүргүүлэх бөгөөд Кредит КЭ гэрээнд заасны дагуу Төлбөрийн мэдээлэлд заасан Заавал төлөх төлбөрийн хэмжээг, эсхүл Төлбөрийн мэдээлэлд заасан нийт Төлбөрийг тухайн сарын Төлбөр төлөх өдөр багтаан төлнө.
- 3.2. Кредит КЭ нь сар бүр зөвхөн Заавал төлөх төлбөрийг төлсөн бөгөөд Кредит зээлийн хугацааг сунгаж үргэлжлүүлэн ашиглахгүй тохиолдолд Ашигласан зээлийн нийт үлдэгдэл, хүүгийн төлбөр, үйлчилгээний хураамж, гүйлгээний болон хугацаа хожимдуулсан тохиолдолд тооцогдох шимтгэл зэргийг тооцож Кредит зээлийн хугацаа дуусгавар болоход бүрэн төлнө.
- 3.3. Кредит зээлийн хугацаа дуусахад талуудын аль нэг нь гэрээний хугацааг сунгахгүй байх шийдвэр гаргасан бөгөөд гэрээний 3.5, 5.1.8-д заасан харилцах, хадгаламжийн дансан дахь үлдэгдэл нь нийт төлбөрийг төлж хүрэлцэхгүй бол Кредит КЭ-ийн банкин дахь бусад дансаас Банк үл маргах журмаар суутган төлүүлнэ.
- 3.4. Кредит КЭ нь төгрөгийн картын Төлбөрийг гадаад валютаар төлөхийг хүсвэл Төлбөр хийх тухайн өдрийн Банкны худалдаж авах ханшаар тооцно.
- 3.5. Кредит КЭ нь картын зарцуулалтаа өөрийн ижил төрлийн валютын тоот хадгаламж эсвэл харилцах данснаас автоматаар суутгуулан эргэн төлөлтөө төлж болно.
- 3.6. Гэрээний 3.5-д заасан автомат суутгалын гүйлгээ нь КЭ-ийн эргэн төлөлтөө төлөх эцсийн өдөр байх бөгөөд сар бүр нэг удаа хийгдэнэ.
- 3.7. Гэрээний 3.6-д заасны дагуу суутгал хийгдэх үед холбогдох дансны үлдэгдэл хүрээгүйн улмаас Кредит картын Төлбөр төлөгдөөгүй тохиолдолд уг Төлбөрийг Кредит КЭ өөрөө хариуцан хийнэ. Дансан дахь үлдэгдэл хүрээгүйн улмаас автомат суутгалын гүйлгээ хийгдээгүйгээс болж бодогдсон шимтгэл, хураамж, хүүгийн төлбөрийг Кредит КЭ хариуцна.
- 3.8. Кредит КЭ гэрээний 3.5-д зааснаас бусад хэлбэрээр /Цахим банк, АТМ, Бэлэн бус шилжүүлгийн гүйлгээ, Банкны салбар нэгжид хандаж бэлэн мөнгөөр/ Кредит картын Төлбөр төлөх боломж нь нээлттэй байна.
- 3.9. Банк нь энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэлийг Гэрээний 5.1.8-д заасан барьцаа буюу хууль тогтоомжид заасан журмаар хангуулна. Дээрх үндэслэлээр данснаас хийсэн зарлагын гүйлгээг Кредит КЭ-ийн даалгавраар хийсэн гүйлгээ гэж үзнэ.

ДӨРӨВ. ЗЭЭЛИЙН ЭРХИЙГ ХААХ, ХЭМЖЭЭГ ӨӨРЧЛӨХ

- 4.1. Банк дараах тохиолдолд зээлийн эрхийн хэмжээг өөрчилж болно. Үүнд:
 - 4.1.1. КЭ-ийн сарын орлого нь нэмэгдсэн тохиолдолд хүсэлтийг нь үндэслэн Банкны журмын дагуу нэмэгдүүлж болно.
 - 4.1.2. Зээлийн хэмжээг доорх тохиолдолд зохих хэмжээнд хүртэл бууруулж болно. Үүнд:
 - 4.1.2.1. Банк нь КЭ-ийн зээлжих чадвар буурсан тухай мэдээлэл авсан тохиолдолд;
 - 4.1.2.2. КЭ-ийн санхүүгийн чадвартай холбоотой бусад нөхцөл байдал бий болсон тохиолдолд.
- 4.2. Кредит картын зарлагын гүйлгээ хийх эрх дараах тохиолдолд түр хаагдана. Үүнд:
 - 4.2.1. Кредит картын Заавал төлөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд зарлагын гүйлгээ гаргах эрх энэхүү гэрээний 2.9-д заасан нөхцөлийн дагуу системд автоматаар хаагдана;
 - 4.2.2. Зарлагын гүйлгээ гарах эрх түр хаагдсаны дараа програмд бодогдсон зээлийн Заавал төлөх төлбөрийн хэмжээгээр төлөлт хийсэн тохиолдолд 1 өдрийн дараа гүйлгээ хийх эрх нээлттэй болно;
 - 4.2.3. КЭ гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд Банкны ажилтан гэрээний үүргээ биелүүлэх хүртэлх хугацаанд түр хугацаагаар картын зарлагын гүйлгээ гарах эрхийг хаана.
 - 4.2.4. Цалингаар баталгаажсан Кредит картын хувьд цалингийн орлого зогссон, Банкны картаар цалин авахаа больсон эсхүл КЭ-ийн хөрөнгийн байдал илэрхий доройтсон гэж Банк үзсэн тохиолдолд;
 - 4.2.5. Хуульд заасан бусад үндэслэл.
- 4.3. Кредит картыг дараах тохиолдолд бүр хаана.
 - 4.3.1. Зээлийн зарцуулалт, хүү, шимтгэл, хураамж бүрэн төлөгдсөний дараа КЭ-ийн хүсэлтээр;
 - 4.3.2. КЭ зээлийн эрхээ 1 жилийн хугацаанд огт ашиглаагүй бол Банкны санаачилгаар.
 - 4.3.3. Кредит зээлийн хугацаа дууссан бөгөөд КЭ зээлийн зарцуулалт, хүү, шимтгэл, хураамж бүрэн төлсний дараа;
- 4.4. Кредит картын зарцуулалтаа төлөөгүй тохиолдолд хүү, шимтгэл нь тэдгээрийн Төлбөрийг бүрэн төлөх өдөр хүртэлх хугацаанд бодогдоно.

ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ, ХҮЛГЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Банкны эрх

- 5.1.1. Банк нь 4-р зүйлд заасан үндэслэлээр зээлийн эрхийн хэмжээг багасгах, зарлагын гүйлгээ гарах эрхийг түр хаах, бүр хаах эрхтэй;
- 5.1.2. Шаардлагатай тохиолдолд Кредит картын Төлбөрийг КЭ-ийн Банкинд дахь данснаас суутгах болон ирээдүйд карт эзэмшигчийн нэр дээр нээгдэх данснаас үл маргах журмаар суутган авах эрхтэй;
- 5.1.3. Хадгаламж барьцаалсан Кредит карт хугацаа хэтэрсэн бол хадгаламжийн данснаас хэсэгчлэн суутгаж картын дансанд шилжүүлж Кредит картын өрийг барагдуулах бөгөөд барьцааны дүнд хараглуулан Кредит зээлийн хэмжээг бууруулах эрхтэй;
- 5.1.4. Гэрээний 5.1.3-д заасан нөхцөлөөр хугацаатай хадгаламжаас суутгал хийсэн тохиолдолд журмын дагуу хугацаатай хадгаламжийн хүү хугацаагүй хадгаламжийн хүүний **50** хувиар тооцогдоно.
- 5.1.5. Картаар сэжигтэй гүйлгээ гарсан тохиолдолд КЭ-тэй /холбоо барих утас, имэйлээр/ холбогдож чадаагүй бол Банкны зүгээс картын зарлагын гүйлгээг түр хугацаагаар хаах эрхтэй;
- 5.1.6. Луйврын гүйлгээний эрсдэлээс сэргийлэх зорилгоор Банк картаар гарсан сэжигтэй гүйлгээг хянаж, КЭ-тэй холбогдож баталгаажуулах эрхтэй;
- 5.1.7. КЭ нь энэхүү гэрээг зөрчсөн тохиолдолд Банк картын гүйлгээг зогсоох эрхтэй;
- 5.1.8. Хэрэв КЭ хадгаламж эсвэл цалин буюу цалингийн данс барьцаалан Кредит карт нээлгэсэн бол Банк тоот дансыг хяналтдаа авч барьцаалсан гэж тооцох бөгөөд Кредит зээлийг төлүүлэхэд шаардлагатай дүнгээр хадгаламжийн дансны зарлагын гүйлгээг зогсооно.

- 5.1.9. КЭ Заавал төлөх төлбөр, Кредит зээлийн нийт үлдэгдлийг төлөх зэрэг үүргээ биелүүлээгүй бол Банк энэ гэрээний 5.1.8-д заасан данснаас үүргийн зөрчлийг үл маргах журмаар шаардлагаа хангуулах эрхтэй. Барьцаалагдсан хадгаламжийн дансыг Банк холбогдох дүнгээр битүүмжилнэ;
- 5.1.10. Энэхүү гэрээний 4.2, 5.1.9-д заасан нөхцөл үүссэн буюу гэрээний үүргийн зөрчил үүссэн тохиолдолд банк барьцаалсан данс болон КЭ-ийн бусад данснаас гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хэмжээгээр суутгал хийх эрхтэй;
- 5.1.11. Монгол Улсад байрлах АТМ-д хураагдсан картыг тухайн өдрөөс хойш 3 сарын хугацаанд банкаас аваагүй бол картыг хүчингүй болгох;
- 5.1.12. КЭ нь картаар хийгдсэн гүйлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд энэ тухайгаа гэрээний 5.3.1-д заасан хугацааны дотор Банкинд хүсэлт ирүүлээгүй буюу хугацаа хоцорч хүсэлт ирүүлсэн бол хүсэлтийг хүлээн авахгүй байх эрхтэй;
- 5.1.13. КЭ хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дугуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид “Маргаантай гүйлгээ” гэх)-г шийдвэрлэхийн тулд маргаантай гүйлгээний дүнгээр дансанд түр хаалт тавих;
- 5.1.14. КЭ захиалсан картаа Шуудангийн үйлчилгээгээр хүлээн авахаар ХШЕН-д заасан хураамжийг төлсөн боловч шууданг хүлээн авах хаягтаа байгаагүй, эсвэл хаягаа алдаатай бүртгүүлсэнээс болж картаа хүлээн авч чадаагүй бол шимтгэлийг банк буцаан олгохгүй байх;
- 5.1.15. КЭ-ийн буруугаас Банк, ҮБ болон бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол КЭ-ийн картын болон бусад данснаас үл маргах журамаар суутган авах, дансан дахь үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
- 5.1.16. Банк гэрээнд өөрчлөлт оруулах талаар карт эзэмшигчдэд хуанлийн 30 /гуч/ хоногийн өмнө банкны холбогдох суваг/вебсайт, интернэт банк/-р мэдээлснээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд карт эзэмшигч заасан хугацаанд гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 5.1.17. КЭ-ийн картаараа хийсэн төлбөр, тооцоог Монгол улсын картын сүлжээнд хийгдсэн гүйлгээний хувьд тухай бүр, Олон улсын картын сүлжээнд хийгдсэн бол гүйлгээ хийгдснээс хойш 30 хоногийн дотор холбогдох данснаас нь суутган авч байх
- 5.1.18. Гэрээний 2.3-д заасан Кредит зээлийн хугацаа дууссан бол КЭ-ээр шимтгэл, хураамж кредит зээлийн хүү, кредит зээлийн дүнг хугацаа дууссан даруйд бүрэн төлүүлж Кредит зээлийг хаах.

5.2. Банкны үүрэг

- 5.2.1. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсноор Банк Кредит картын зээлийн лимит нээнэ;
- 5.2.2. Банкны зүгээс картыг хаасан тохиолдолд утсаар болон имэйл хаяг руу карт эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй;
- 5.2.3. Банк Кредит карттай холбоотой ХШЕН өөрчлөгдөх үед Банкны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй;
- 5.2.4. Банк нь Монголбанкны дүрэм, журамд заасны дагуу бусад зээлийн адил Монголбанкны зээлийн мэдээллийн санд карт эзэмшигчийн Кредит картын зээлийн ангиллыг тухай бүрд нь бүртгүүлнэ;
- 5.2.5. Кредит КЭ-д Кредит картыг хүлээлгэн өгөх, идэвхжүүлэх, гэрээний нөхцөлийг тайлбарлах, хэрэглэх заавраар хангана;
- 5.2.6. Кредит картын Төлбөрийн мэдээллийг Кредит КЭ-ийн Банкны системд бүртгэлтэй цахим хаягаар хүргүүлнэ;
- 5.2.7. Кредит КЭ-ийн хувийн болон гүйлгээний талаарх мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, хуульд зааснаас бусад үндэслэлээр задруулахгүй;
- 5.2.8. Банкны АТМ болон бусад терминал дээр болон системд гарсан техникийн саатлын улмаас Кредит КЭ-д мөнгийг олгоогүй нь тогтоогдсон тохиолдолд мөнгөн дүнг холбогдох журмын дагуу харилцагчийн картын дансанд буцаан олгох үүрэгтэй;
- 5.2.9. КЭ дэд карт нээлгэх, алдаж үрэгдүүлсэн, гэмтсэн карт дахин авах талаар гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- 5.2.10. Бусад банк болон гадаадын банкны сүлжээнд гарсан төлбөр тооцоотой холбоотой маргааныг Монголбанкны төлбөрийн картын журам, Виза интернэйшнл байгууллага болон бусад картын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журам, “Улаанбаатар хотын банкны картын маргаантай гүйлгээг шалгах, шийдвэрлэх журам”, холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
- 5.2.11. Банк нь картаар гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг /цахим шуудангаар г.м/ үнэ төлбөргүй КЭ-д мэдэгдэх нэгээс доошгүй суваг үйлчилгээний нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх.
- 5.2.12. Монгол улсын картын сүлжээнд Картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар КЭ банкинд хүсэлт гаргасан бол Банк АТМ, ПОБ -ын гүйлгээний хүсэлтийн хариуг Карт хүлээн авагч банкинд бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг ажлын 10 хоногийн дотор, Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг хуанлийн 30-45 хоногийн дотор КЭ-д мэдэгдэх;
- 5.2.13. Энэхүү гэрээний 5.2.12-д заасны дагуу хүсэлтийн хариуг КЭ хүлээн зөвшөөрөхгүй бол гэрээний 5.2.10-д заасан журам зааврын дагуу шийдвэрлэнэ.

5.3. Карт эзэмшигчийн эрх

- 5.3.1. Монгол улсын картын сүлжээнд картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар АТМ, ПОБ -ын гүйлгээ бол гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 40 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээ бол ажлын 60 хоногийн дотор, Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ-ын гүйлгээ бол хуанлийн 75 хоног, ПОС-ын гүйлгээ бол хуанлийн 120 хоногийн дотор Банканд биер ирж бичгээр эсвэл Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн лавлах дугаар /1800-1800/-т хандаж хүсэлт гаргах;
- 5.3.2. Кредит картын үлдэгдэл болон гүйлгээний мэдээллийг Банкаас гаргуулах;
- 5.3.3. Кредит картын зээлийн лимитийн хэмжээг нэмэгдүүлэх, хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргах;
- 5.3.4. КЭ нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкаас шаардах эрхтэй.
- 5.3.5. Карт гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн бол карт нөхөж авах, ПИН кодоо мартсан бол шинээр авах хүсэлтийг Банканд гаргаж, шийдвэрлүүлэх;

5.4. Карт эзэмшигчийн үүрэг

- 5.4.1. КЭ нь Кредит зээлийн хугацааг сунгуулах хүсэлтээ хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө Банкинд мэдэгдэх үүрэгтэй;
- 5.4.2. КЭ нь өөрийн карт болон бүх дэд Кредит картын зарцуулалт, хүү, шимтгэл, хураамжийг бүрэн хариуцаж, зарцуулалтыг Төлбөр төлөх өдрөөс өмнө төлөх үүрэгтэй.
- 5.4.3. КЭ Кредит картанд үүссэн зээлийн зарцуулалт, түүний хүү, шимтгэл, хураамж болон ХШЕН-д заасан шимтгэл хураамжийг гэрээнд заагдсан хугацаа, нөхцөлийн дагуу төлөх үүрэгтэй.

- 5.4.4. КЭ-ийн талаарх мэдээлэл өөрчлөгдөх бүрд Банканд мэдэгдэж шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
- 5.4.5. Аливаа шалтгаанаас хамааран Төлбөрийн мэдээлэл КЭ-ийн цахим хаягт очоогүй бол энэ нь Төлбөр төлөх үүргээ биелүүлэхгүй байх, хүү, шимтгэлээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд картын хэрэглээгээ Төлбөрийн мэдээллээс үл хамааран шалгаж Төлбөрийг Төлбөр төлөх өдөрт багтаан төлөх үүрэгтэй.
- 5.4.6. Дансны гүйлгээний хуулгыг тогтмол шалгаж, маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй ямар нэгэн гүйлгээ хийгдсэн тохиолдолд Гэрээний 5.3.1-д заасан хугацааны дотор банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүй эсвэл заасан хоногоос хойш мэдээлсний улмаас үүссэн хохирлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.7. КЭ болон Дэд КЭ нь картын нууцлал болох картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, картын ПИН код, интернет ПИН код, Картын соронзон туузанд бичигдсэн мэдээллийн нууцлалыг нарийн чанд хадгалах, бусдад мэдэгдэхгүй байх, картаа бусдад ашиглуулахгүй байх үүрэгтэй бөгөөд картын нууцлалаа алдсанаас үүсэх аливаа эрсдэл, хохирол зардлыг бүрэн хариуцах;
- 5.4.8. Өөрийн карт буюу пин кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн, картын пин код, картын мэдээллийг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн /1800-1800/ дугаарын утсанд мэдэгдэж хаалгах эсвэл Цахим банкны үйлчилгээгээр нэн даруй картаа өөрөө хаах бөгөөд эдгээр үйлдлийг хийгээгүйн улмаас үүсэх хохирлыг өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.9. Банкны харилцагчийн мэдээллийн төвөөр буюу зайнаас үйлчилгээ авсантай холбоотой үүссэн аливаа маргаан, хохирол зардлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
- 5.4.10. Шуудангийн үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авахдаа дугтуйны битүүмжийг сайтар шалган авах ёстой бөгөөд битүүмж задарсан бол картыг хүлээн авахгүй байж банкинд энэ талаар нэн даруй мэдэгдэх;
- 5.4.11. Шуудан үйлчилгээг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд ашиглах;
- 5.4.12. Шуудан үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авсан бол өөрийн бүртгэлтэй Цахим банк үйлчилгээгээр картыг идэвхжүүлэх;
- 5.4.13. Дотоодын болон олон улсын Кредит картын хувьд Монгол улсын төлбөрийн сүлжээнд КЭ-ийн хийсэн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Банкны журам, заавар, Монолбанкны журам, зааврын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд КЭ-д хохирол учирхаар шийдвэрлэгдсэн бол хохирлыг бүрэн хариуцах;
- 5.4.14. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Виза интернэйшнл байгууллагын холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд Маргаан КЭ-ийн эсрэг шийдвэрлэгдсэн бол хохирол, үр дагаварыг бүрэн хариуцах;
- 5.4.15. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшнл байгууллага болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын сүлжээнд КЭ-ийн хийсэн гүйлгээ, тухайн гүйлгээний валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болох ханшийн зөрүү, Виза интернэйшнл байгууллага болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын зүгээс ХШЕН-өөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг карт эзэмшигч бүрэн хариуцах;
- 5.4.16. Олон улсын Кредит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд хийсэн бүх гүйлгээ нь эхлээд УБХБ-ны бэлэн бус ам.доллар зарах ханшаар хөрвөх бөгөөд картын гүйлгээний валют нь төгрөг, ам.доллараас өөр валют бол ам.доллар тухайн гуравдагч валюттай харьцах ханш нь Виза интернэйшнл байгууллагын ханш байх бөгөөд энэхүү ханшын зөрүүг харилцагч бүрэн хариуцах үүрэгтэй;
- 5.4.17. Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад КЭ нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан зардлыг бүрэн хариуцах;
- 5.4.18. Гэрээний 2.3-д заасан Кредит зээлийн хугацаа дууссан бол КЭ шимтгэл, хураамж кредит зээлийн хүү, кредит зээлийн дүнг хугацаа дуусахаас өмнө бүрэн төлж барагдуулна.

5.5. Хариуцлага

- 5.5.1. КЭ өөрийн картын дугаар, нэр, хүчинтэй хугацаа, CVV код, ПИН код болон интернэт худалдаанд ашиглагдах интернэт ПИН кодыг бусдад алдсаны улмаас хийгдсэн луйврын гүйлгээний хохирол үр дагварыг бүрэн хариуцна.
- 5.5.2. КЭ картаа алдсан, бусдад картаа шилжүүлсний улмаас хийгдсэн Бэлэн зарлага болон Бэлэн бус гүйлгээгний үр дагвар, хохиролыг бүрэн хариуцна.
- 5.5.3. КЭ өөрийн Кредит данс дээр олгосон Дэд картын бүх зарлагын гүйлгээ, хүү, шимтгэл, хураамжыг бүрэн хариуцна.
- 5.5.4. КЭ зөвшөөрөлгүй хийгдсэн гэх гүйлгээг энэхүү гэрээнд заасан хугацааны дотор Банканд мэдэгдээгүйгээс үүдэн гарах эрсдлийг бүрэн хариуцна.
- 5.5.5. Олон улсад ашиглагдах Кредит КЭ-ийн Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн гүйлгээтэй холбоотой асуудлыг Банк харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох журмын дагуу харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирол, үр дагаварыг бүрэн хариуцна;
- 5.5.6. Дотоодод эсвэл олон улсад ашиглагдах Кредит картын хувьд дотоодын банкны сүлжээнд гаргасан Төлбөрийн картын маргаантай холбоотой асуудлыг харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох банкуудтай харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирлыг бүрэн хариуцна;
- 5.5.7. Картын хэвийн тасралтгүй найдвартай ажиллагааг Банк хариуцна;
- 5.5.8. Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Банк хариуцлага хүлээхгүй.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 6.2. Картаар хийгдсэн маргаантай эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа аливаа гүйлгээг дотоодын банкны сүлжээнд гарсан маргаан бол Улаанбаатар хотын банкны болон Монголбанкны гаргасан журам заавраар, олон улсын сүлжээнд гарсан маргаан бол Виза интернэйшнл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Олон улсын сүлжээнд хийсэн гүйлгээний маргааны хувьд Виза интернэйшнл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэсэн арбитрын шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- 6.4. Талуудын хооронд үүссэн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй, буруутай тал нь тогтоогдоогүй байхад, Банкны нэр хүндэд халдах, гутаах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээ тараахыг хориглоно. Үүний улмаас Банканд учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.
- 6.5. Энэ гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын хуулийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.6. Талуудын хооронд үүсэх маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. Энэ заалт гэрээний 6.3-т заасан маргаанд хамаарахгүй.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 7.1. Талууд гэрээний зохицуулалт, бүтээгдэхүүний нөхцөлтэй бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн бөгөөд сайн дурын үндсэн дээр энэхүү гэрээг байгуулсан болно.
- 7.2. Кредит зээлд данс дахь хөрөнгө барьцаалсан бол Хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг, бусад төрлийн хөдлөх хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бол холбогдох барьцааны гэрээг тус тус мөрдөнө.
- 7.3. Энэ гэрээгээр зохицуулагдаагүй бусад асуудал Монгол улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдана.
- 7.4. Энэ гэрээг 2 эх хувь үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга/ тэмдэг дарж баталгаажуулснаар, хүчин төгөлдөр болно.
- 7.5. Энэ гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд бичгээр үйлдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийн гэрээ нь энэхүү гэрээний 7.4-т заасан нөхцөл хангагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 7.6. Энэхүү гэрээний хавсралтаар үйлдэгдэх Барьцааны гэрээ, Батлан даалтын гэрээ, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд эдгээр гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл Кредит картын гэрээг зөрчсөнтэй адилтган тооцно.
- 7.7. Энэ гэрээний дагуу эзэмшиж буй картаар хийсэн гүйлгээний хувьд өөрийн картын мэдээллийг цахим гүйлгээний талбарт оруулсан; картыг ПОС, ПОБ, АТМ төмөрөмжд уншуулсан; мөн гүйлгээг хийхэд Картын ПИН код, эсхүл Интернэт ПИН код шаардсан бол тэдгээр кодыг оруулсан зэргийг холбогдох гүйлгээний баримтад зурсан гарын үсэг зурсантай адилтгаж тооцно.
- 7.8. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсноос гэрээнд заасан үндэслэлээр цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 7.9. Энэ гэрээг байгуулах өдрийн байдлаар мөрдөгдөж буй Картын үйлчилгээний ХШЕН-ийг гэрээний хавсралтад тусгасан бөгөөд уг нөхцөлийг Банк энэ гэрээнд заасан журмаар өөрчилж болно. КЭ нь энэхүү нөхцөлийг гэрээний Хавсралт №1 -д дурдсан ХШЕН-тэй танилцаж зөвшөөрсний үндсэн дээр гэрээ байгуулсан болно.

Нэмэлт үйлчилгээ: Автомат суутгал /Энэ хэсгийг бөглөснөөр кредит картын суутгал автоматаар хийгдэхийг зөвшөөрсөнд тооцно. Суутгал хийх өдөр доорх дансны үлдэгдэл хүрэлцэхгүй бол суутгал хийгдэхгүй болохыг анхаарна уу./

Сар бүрийн зарцуулалтаа автоматаар данснаасаа суутгуулах эсэх: Гийм Үгүй

Суутгал хийх дансны дугаар:

Данс эзэмшигчийн нэр:

Эргэн төлөх дүн: Заавал төлөх төлбөр

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гэрээний нөхцлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон картын үйлчилгээний хүү, шимтгэлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.

Банкийг төлөөлж:

Харилцагчийн менежер/Лавлагааны ажилтан:

Гарын үсэг: _____

Салбар нэгжийн

Захирал: _____

Гарын үсэг, тамга: _____

Кредит карт эзэмшигч:

Нэр: _____

Гарын үсэг: _____

Регистр №: _____

КРЕДИТ КАРТЫН ХҮҮ, ШИМТГЭЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нөхцөл		Олон улсын карт	
Кредит картын дансны валют			
Жилийн хураамж /Картын хүчинтэй хугацаанд жил бүр суутган авна/			
Карт нөхөн авах / алдсан, гээсэн, гэмтээсэн/			
6 цагийн дотор карт хэвлүүлэх үйлчилгээний хураамж			
Картын ПИН код солих	УБХБ болон ХХБ-ны АТМ		
	Гэрээт банкуудын АТМ		
	УБХБ-ны салбар		
Зээлийн хүү	Бэлэн бус гүйлгээ		
	Бэлэн гүйлгээ		
Заавал төлөх төлбөрийн доод хэмжээ			
Заавал төлөх төлбөрийг төлөх өдөр			
Хугацаа хэтрүүлсний шимтгэл <i>/заавал төлөх төлбөрийг төлөх ёстой хугацаанд багтаж төлөөгүй бол тооцно/</i>			
Өдрийн гүйлгэний хязгаар	АТМ болон Банкны салбараас картаар бэлэн мөнгө авах	Тоо	
		Дүн	
	Худалдан авалт хийх	Тоо	
		Дүн	
Картын ПИН код буруу хийх боломж	Тоо		
Кредит зээлийн лимитээс Бэлнээр зарцуулах хязгаар			
АТМ-р үлдэгдэл шалгах	Олон улсын АТМ-ээр		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээр		
	Гэрээт банкны АТМ-ээр		
	Бусад банкны АТМ		
АТМ –ээс бэлэн мөнгө авах	Олон улсын АТМ-ээс		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээс		
	Гэрээт банкны АТМ-ээс		
	Бусад банкны АТМ-ээс		
Банкны Салбар, Тооцооны төвөөс бэлэн мөнгө авах	Гадаадын банкны салбараас		
	УБХБ-ны салбараас		
	ХХБ-ны салбараас		
	Гэрээт банкны салбараас		
	Бусад банкны АТМ-ээс		